



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/334

Арвайхээр

«Дуудлага худалдаа зохион байгуулах тухай»


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолын “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 3.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хархорин сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 33,712,000 (гучин гурван сая долоон зуун арван хоёр мянга) төгрөгийн үнэ бүхий 2408 м.кв газрыг дуудлага худалдаагаар худалдсугай.

2.Газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдааг 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсугай.

3.Газрын дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, орлогыг “Орон нутгийн өмч худалдсаны орлого” дансанд төвлөрүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100715